



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

**Хэлэлцэх асуудлын
ерөнхий төлөвлөгөө батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ

“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 19 өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНД ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хуралд танилцуулах нэгж	Гарах шийдвэр
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай	1 дүгээр сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
2	Компанийн хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн явцын танилцуулга мэдээлэл хийх	2 дугаар сар	Төслийн хэрэгжилт, хяналтын хэлтэс	Танилцуулга
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг чөлөөлж, томилох тухай	3 дугаар сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
4	Компаний 2022 санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн тухай	3 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
5	Ногдол ашиг хувиарлах тухай	3 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
6	Гүйцэтгэх захиралтай байгуулсан 2022 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх тухай	3 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Захиргаа удирдлагын газар	Тогтоол
7	Гүйцэтгэх захирлыг чөлөөлж, томилох, жинхлэн томилох тухай	5 дугаар сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
8	Гүйцэтгэх захирлыг чөлөөлж, томилсонтой холбогдуулан ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг байгуулах тухай	5 дугаар сар	ТУЗ-ийн дарга	Тогтоол
9	Компанийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг чөлөөлж, томилох талаар зөвшилцөх тухай	5 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
10	Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцыг хэлэлцэх,	5 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
11	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй хөрөнгийг актлах тухай	6 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол

12	Хөгжлийн банкны барьцаанаас чөлөөлөгдсөн ТОСК-ийн эзэмшлийн газруудыг нийтийн эзэмшилд шилжүүлэх, шинэчлэн бүртгэх тухай тогтоолын төслийг хэлэлцэх	6 дугаар сар	Төслийн хэрэгжилт, хяналтын хэлтэс	Тогтоол
13	Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан шаардлагын хүрээнд төсөв батлах тухай	6 дугаар сар	Захиргаа, удирдлагын газар	Тогтоол
14	“Буянт-Ухаа 1” хорооллын С-473, В-484 тоот автозогсоолын төлбөрийг буцаах асуудлыг хэлэлцэх	6 дугаар сар	Хөрөнгийн удирдлагын газар	Тэмдэглэл
15	Түрээсийн орон сууцны санд шилжсэн Хангай хотхоны 223 айлын орон сууцыг иргэдэд өмчлүүлэхтэй холбоотойгоор үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны татвар төлөх асуудлыг хэлэлцэх	6 дугаар сар	Хөрөнгийн удирдлагын газар	Тэмдэглэл
16	Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ аймгууд дахь дуусаагүй барилгын суурьтай газруудын асуудлыг хэлэлцэх	6 дугаар сар	Төслийн хэрэгжилт, хяналтын хэлтэс	Тэмдэглэл
17	Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай	6 дугаар сар	Захиргаа, удирдлагын газар	Тогтоол
18	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх тухай	6 дугаар сар	Захиргаа, удирдлагын газар	Тогтоол
19	Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх асуудлыг хэлэлцэх	6 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
20	Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх	8 дугаар сар	Дотоод аудитор	Тэмдэглэл
21	Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн явцыг танилцуулах	8 дугаар сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
22	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй ер, авлагын асуудлыг хэлэлцүүлэх	9 дүгээр сар	Захиргаа, удирдлагын газар	Тэмдэглэл
23	Хөгжлийн банкны бондын ер төлбөрийн эргэн төлөлтийн асуудлаар мэдээлэл, танилцуулга хийх	9 дүгээр сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл
24	Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцыг хэлэлцэх	10 дугаар сард	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тэмдэглэл

25	Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэх	10 дугаар сард	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	Тогтоол
26	Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгасан үр дүнгийн урамшууллыг олгох асуудлыг хэлэлцэх	12 дугаар сард	Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Захиргаа, удирдлагын газар	Тогтоол
27	Цаг үеийн холбогдолтой бусад асуудал	Тухай бүр	Гүйцэтгэх захирал	Тогтоол, тэмдэглэл